

ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотын агаарын бохирдол, тэр дундаа нарийн ширхэглэгт тоосонцор РМ-ыг бууруулах зорилттой хэрэгжиж буй УБЦАТ-ийн хүрээнд, агаарын бохирдол ба хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар иргэд олон нийтэд таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн газар (НЭМГ) ба АШУИС-ийн Орчны эрүүл мэндийн сургуультай хамтран семинар, сургалт, өдөрлөг зохион байгуулах.

Арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд НЭМГ болон АШУИС-ийн Орчны эрүүл мэндийн сургуультай шат дараатай уулзалтуудыг зохион байгуулж, хамтран ажиллах талаар ярилцаж, арга хэмжээний хөтөлбөрийг тохиролцож баталлаа. (ХАВСРАЛТ 1,2,3: Уулзалтын тэмдэглэл)

Арга хэмжээ нь дараах үе шатуудаас бүрдэнэ:

Арга хэмжээ 1: Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн эрүүл мэндийн нэгтгэлүүд, харьяа өрхийн эмнэлэгүүд, эмч албан хаагчдад зориулсан семинар.

Арга хэмжээ 2: Хамтран оролцогч байгууллагуудтай зөвшилцөж сонгосон БГД-ийн 22, БЗД-ийн 21, ЧД-ийн 12 хороодын өрхийн эмнэлэгийн эмч ажилчдад зориулан орчны агаарын бохирдол болон ирэний ороолцоо сэдвүүдээр сургалт зохион байгуулах.

Арга хэмжээ 3: Сонгогдсон 3 өрхийн эмнэлэгүүдэд өдөрлөг зохион байгуулж эмч, эмнэлэгийн ажилчид хороодын иргэдэд (i) орчны агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар мэдээллэх, (ii) гарын авлага, витаминь үрэл, салфетка тараах, (iii) иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

Арга хэмжээ 4: Улаанбаатар хотын хэмжээнд 142 өрхийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа. УБЦАТ-ийн зүгээс агаарын бохирдлын нөлөөллийг харуулсан постеруудыг нийт өрхийн эмнэлэгүүдэд тарааж байрлуулсан ба бүрэн шаталттай зуухны шторкуудыг эмнэлэгүүдийн дэлгэцээр дамжуулах. Тухайн өдөр өрхийн эмнэлэгүүдээр ирж үйлчлүүлсэн иргэдээр санал асуулгын хуудас бөглүүлж судалгаа авсан.

АРГА ХЭМЖЭЭ 1:

УЛААНБААТАР ХОТЫН ТӨВИЙН 6 ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГТГЭЛ,
ХАРЬЯА ӨРХИЙН ЭМНЭЛЭГҮҮДИЙН ЭМЧ, АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН
АГААРЫН БОХИРДОЛ БА ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ
СЕМИНАР

Хаана:	ЧД-ийн эрүүл мэндийн сургалтын төв
Хэзээ:	2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр


Улаанбаатар хотын агаарын бохирдлын дийлэнхи хувийг эзлэж буй нарийн ширхэглэгт тоосонцор РМ-ыг бууруулахад нийслэлийн иргэд олон нийтийн оролцоо ба үүрэг чухал ач холбогдолтой байгаа. Энэ талаархи мэдээ мэдээллийг олон нийтэд түгээх ажлын хүрээнд, Нийслэлийн эрүүл мэндийн газар, АШУИС-ийн Орчны эрүүл мэндийн сургуультай хамтран өдөрлөг арга хэмжээг зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд зохион байгуулагчид:

1. УБЦАТ-ийн товч танилцуулга



Зураг 1: УБЦАТ-ийн талаархи илтгэл

2. Агаарын бохирдол болон түүний эх үүсвэр, найрлага



Зураг 2: Улаанбаатар хотын агаарын бохирдол ба эх үүсвэрүүд илтгэл

3. Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл сэвдүүдээр



Зураг 3: Агаарын бохирдол ба хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө илтгэл

илтгэл танилцуулж, 6 дүүргийн ЭМН-болон өрхийн эмнэлэгүүдийн нийт 20 эмч албан хаагчид оролцлоо.



Зураг 4: Оролцогчид

Арга хэмжээний зорилго нь иргэдийн байнга үйлчлүүлдэг эрүүл мэндийн төв болон хороодын өрхийн эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдаар дамжуулж (i) агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл, (ii) гадаад болон дотоод орчны агаарын бохирдлоо багасгахад иргэд өөрсдөө юу

хийж чадах, (iii) хэрэгжиж буй арга хэмжээнд иргэд идэвхитэй оролцсоноор ямар ахиц гарах талаар мэдээллийг түгээх юм.

Энэ арга хэмжээний үеэр нийслэлийн БГД, БЗД болон ЧД-с 1/1 өрхийн эмнэлэгийг сонгож 2-р шатны арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ярилцсан.

Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулахад иргэд олон нийтийг идэвхижуулэх зорилгоор УБЦАТ нь НЭМГазартай хамтран хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд БГД-ийн 22 хороо, ЧД-ийн 12 хороо, БЗД-ийн 21 хорооны өрхийн эмнэлэгүүдийг сонгон, эмч ажилчидтай уулзаж арга хэмжээний талаар танилцуулан сургалт хийх өдрөө товллоо.

АРГА ХЭМЖЭЭ 2:

СОНГОГДСОН ХОРООДЫН ӨРХИЙН ЭМНЭЛЭГҮҮДИЙН ЭМЧ АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ, СЕМИНАР

БГД-ийн 22-р хорооны өрхийн эмнэлэгийн сургалт 2014 оны 12-р сарын 2- ны өдөр болж өнгөрсөн ба БГД-ийн 10-р, 22-р хорооны нийт 9 эмч ажилчид оролцлоо. УБЦАТ-с: “Улаанбаатар хотын агаарын бохирдол”, “ Агаарын бохирдлыг бууруулахад бидний үүрэг, оролцоо” сэдвүүдээр илтгэл бэлтгэн танилцуулж , иргэдэд агаарын бохирдлын талаар мэдээ мэдээлэл олгох өдөрлөгийн талаар санал солилцлоо. 22-р хорооны өрхийн эмнэлэгийн ажилчид дараах саналыг дэвшүүлсэн нь:



Зураг 5: БГД-ийн 22-р хорооны өрхийн эмнэлэгийн эмч ажилчид

ЧД-ийн 12-р хорооны өрхийн эмнэлэгийн сургалт 2014 оны 12-р сарын 4 – ний өдөр болж нийт 19 эмч ажилчид оролцлоо. УБЦАТ-с: “Улаанбаатар хотын агаарын бохирдол”, “ Агаарын бохирдлыг бууруулахад бидний үүрэг, оролцоо” сэдвүүдээр илтгэл бэлтгэн танилцуулан, цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо.



Зураг 6: ЧД-ийн 12-р хорооны өрхийн эмнэлэгийн эмч ажилчид

БЗД-ийн 21-р хорооны өрхийн эмнэлэгийн сургалт 2014 оны 12-р сарын 5 - ны өдөр болж нийт 13 эмч ажилчид оролцлоо. УБЦАТ-с: “Улаанбаатар хотын агаарын бохирдол”, “ Агаарын бохирдлыг бууруулахад бидний үүрэг, оролцоо” сэдвүүдээр илтгэл бэлтгэн танилцуулан, цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо.



Зураг 7: БЗД-ийн 21-р хорооны өрхийн эмнэлэгийн эмч ажилчид

Гурван дүүргийн өрхийн эмнэлэгүүдийн нийт 54 эмч ажилчид оролцож мэдээ мэдээлэл танилцууллаа.

АРГА ХЭМЖЭЭ 3:

ӨРХИЙН ЭМНЭЛЭГҮҮДТЭЙ ХАМТРАН ИРГЭД ОЛОН НИЙТЭД ОРЧНЫ
АГААРЫН БОХИРДЛЫН ТАЛААР МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ӨДӨРЛӨГ

Хаана:	БГД-ийн 22 хорооны өрхийн эмнэлэг
Хорооны хүн ам:	1961 иргэн
Хэзээ:	2014 оны 12-р сарын 11-ний өдөр



Зураг 8: БГД-ийн 22-р хорооны өрхийн эмнэлэгийн өдөрлөг



Зураг 9: БГД-ийн 22-р хорооны өрхийн эмнэлэгийн өдөрлөг



Зураг 10: БГД-ийн 22-р хорооны өрхийн эмнэлэгийн өдөрлөг



Зураг 11: БГД-ийн 22-р хорооны өрхийн эмнэлэгийн өдөрлөг

Хаана:	ЧД-ийн12-р хорооны өрхийн эмнэлэг
Хорооны хүн ам:	3575 иргэн
Хэзээ:	2014 оны 12-р сарын 11-ний өдөр



Зураг 12: ЧД-ийн 12-р хорооны өрхийн эмнэлэгийн өдөрлөг



Зураг 13: ЧД-ийн 12-р хорооны өрхийн эмнэлэгийн өдөрлөг

Хаана:	БЗД-ийн 21 хорооны өрхийн эмнэлэг
Хорооны хүн ам:	1900 иргэн
Хэзээ:	2014 оны 12-р сарын 10-ний өдөр



Зураг 14: БЗД-ийн 21-р хорооны өрхийн эмнэлэгийн өдөрлөг



Зураг 14: БЗД-ийн 21-р хорооны өрхийн эмнэлэгийн өдөрлөг

Тухайн өдөрлөгийн үеэр агаарын бохирдлын хор уршгийн талаар мэдээ мэдээллийн хүртээмж, агаарын бохирдлыг бууруулахад иргэд ямар саналтай байгаа талаар өдөрлөг зохион байгуулсан өрхийн эмнэлэгээр үйлчлүүлсэн 90 иргэдээс санал асуулга авсанаас дараах дүн гарсан:

1. Агаарын бохирдлыг бууруулахад Та оролцоотой юу?
 - Тийм 79
 - Үгүй 4
 - Мэдэхгүй 7
2. Агаарын бохирдлын бууруулахад өөрийн оролцоог Та хир үнэлэж байна?
 - Хангалттай 21
 - Боломжийн 44
 - Хангалтгүй 25
3. Таны оролцоог нэмэгдүүлэхэд юу дутагдаж байна?
 - Хор уршгийн талаар үндэслэлтэй мэдээлэл 6
 - Иргэдийн залхуу хойрго байдал 26
 - Санаачлага 33
 - Санхүүгийн байдал 25
4. Агаарын бохирдлыг бууруулахад яг одоо таны хийж чадах зүйл?
 - Мэдэхгүй буюу оролцоо байхгүй 29
 - Сайжруулсан зуухаа зөв хэрэглэх 28
 - Түр оршин суугчдыг ч мөн зуухаар хангах 2
 - Шалны халаалт, тень хэрэглэх буюу эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, мод тарих, сайжруулсан түлшээр хангах, санхүү санаачлага байвал бүгдийг дэмжинэ гэсэн өөрсдийн саналыг дэвшүүлж мөн иргэдэд энэ талын мэдээ мэдээллийг илүү олон сувгаар түгээх, иргэдийг энэ үйлсэд идэвхижүүлэх зорилгоор сургалт явуулах зэрэг саналуудаа хүргүүллээ.

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Уулзалтын зорилго:	Улаанбаатар хотын агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг иргэд олон нийтэд таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, харъяа байгууллагуудтай хамтран ажиллах талаар.
Огноо:	2014 оны 10 дугаар сарын 14 өдөр
Хаана:	Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар
Уулзсан хүний нэр	Хулан, Мэндсайхан

Байгууллагын тухай:

Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар нь 1938 онд байгуулагдаж, нийслэл хотод эрүүлийг хамгаалахын төрийн захиргааны бие даасан байгууллага байгуулагдсанаас хойш хөгжлийн тодорхой үе шат дамжин, бүтэц зохион байгуулалтын болон үйл ажиллагааны чиглэлийн хувьд өргөжин тэлж иржээ.

Зорилго:

Нийслэлийн хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай үзүүлэн хүн амын эрүүл мэндийг сайжруулж, наслалтыг уртасгахад оршино.

Уулзалтын тухай:

НЭМГ-ын ажилтан Хулан, Мэндсайхан нартай уулзаж нийслэлийн агаарын бохирдол иргэдийн эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаар, мөн иргэд олон нийт агаарын бохирдлыг бууруулахад хүлээх үүрэг оролцооны талаар таниулах, мэдээ мэдээллээр хангах ажлын хүрээнд хамтран ажиллах талаар ярилцлаа.

НЭМГазрын харъяа нийслэлийн хэмжээнд үйл ажилаагаа явуулж буй доорх байгууллагууд хамрагдаж байна:

- Амаржих газрууд
- Төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүд
- Дүүргүүдийн эрүүл мэндийн нэгдгэл, нэгдсэн эмнэлэгүүд
- Хүүхдийн клиник сувилалууд
- Өрхийн эмнэлэгүүд
- Эмийн сангууд
- Хувийн эмнэлэгүүд

НЭМГ нь энэ ажилд хамтран ажиллах тухайгаа илэрхийлэн доорх саналуудыг гаргасан:

- УБЦАТ зүгээс иргэд олон нийтэд хандсан агаарын бохирдлын талаар сурталчилгаа, мэдээ мэдээллийг бэлтгэж өгсөний дагуу өөрийн

харъяа бүх байгууллагуудад тарааж сурталчлах үүрэг өгж, мөн НЭМГ-ын веб болон бусад байгууллагуудын веб-д мэдээллийг байршуулж өгнө.

- НЭМГ нь харъяа байгууллагуудын нийгмийн ажилтан албан хаагчдад сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулдаг. Удахгүй болох энэ арга хэмжээний үеэр салбарын ажилтнуудад агаарын бохирдол болон түүний хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл, эх үүсвэр, хэмжээ тархац г.м талаар дэлгэрэнгүй мэдээллийг УБЦАТ-н зүгээс таницуулж өгөх.
- Цаашид хамтран ажиллах.

НЭМГ нь өөрөө нийслэл хотод эмнэлэгийн төрийн захиргааны бие даасан байгууллага юм, иймд салбарын яам болон бусад холбогдох байгууллагуудын үйл ажиллагаатай харшлахгүй гэдгийг уулзэлтын үеэр онцолж байсан.

ХАВСРАЛТ 2

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Уулзалтын зорилго:	Улаанбаатар хотын агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг иргэд олон нийтэд таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, харъяа байгууллагуудтай хамтран ажиллах.
Огноо:	2014 оны 11 дугаар сарын 07 өдөр
Хаана:	Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар
Уулзалтанд оролцсон хүний нэр:	Мэндсайхан – НЭМГ-ын мэргэжилтэн Өрхийн эмнэлэгүүд хариуцсан мэргэжилтэн Ганчимэг - УБЦАТ Мөнхзул - УБЦАТ

Зорилго:

Улаанбаатар хотын агаарын бохирдол, тэр дундаа нарийн ширхэглэгт тоосонцор РМ-ыг бууруулах зорилттой хэрэгжиж буй УБЦАТ-ийн хүрээнд, агаарын бохирдол ба түүний хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг иргэд олон нийтэд таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлж агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран семинар болон өрхийн эмнэлэгүүдэд өдөрлөг зохион байгуулах талаар.

Уулзалтын тухай:

УБЦАТ-ийн зүгээс НЭМГ-т дараах санал болон урьдчилсан байдлаар төлөвлөсөн арга хэмжээнүүдийг танилцууллаа:

1. Семинарыг 2014/11/17-21 хооронд нэг өдрийг товлон НЭМГ-ын нийт харьяа байгууллагуудын төлөөлөгчдөд зохион байгуулж, НЭМГ, УБЦАТ болон НЭМИС-с холбогдох илтгэлүүдийг танилцуулах,
2. Нийслэлийн төвийн 6 дүүргийн гэр хорооллын өрхийн эмнэлэгүүдийг НЭМГ-тай хамтран сонгож улмаар 2014/11/24-28 хооронд иргэдэд хандсан нээлттэй өдөрлөгийг зохион байгуулах.

НЭМГ-ын төлөөллүүд бидний саналыг хүлээн авч ярилцаж өөрсдийн зүгээс дараах саналыг дэвшүүллээ:

1. НЭМГ нь 14 хоногт нэг удаа нийслэлийн ЭМНэгдэл болон бусад байгууллагуудыг хамарсан нийт 26 дарга удирдлагуудыг цуглуулж тодорхой арга хэмжээг зохион байгуулдаг тул төслийн зүгээс мэдээ

мэдээллээ тэр үед нь танилцуулах нь зүйтэй байх, урьдчилсан байдлаар УБЦАТ-д товлосон өдрөө мэдэгдэнэ.

2. Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй өрхийн эмнэлэгүүдэд агаарын бохирдлын талаар иргэдэд мэдээлэл өгөх өдөрлөг зохион байгуулах нь зөв зүйтэй санаа боловч зардал их шаардсан, үр дүн нь тодорхой харагдахгүй байна. Иймд энэ ажлыг дараах байдлаар зохион байгуулах:

- Нийт 6 дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн нийгмийн ажилтан, өрхийн эмнэлэг хариуцсан дарга гээд 3/3 төлөөллийг цуглуулж нийт 24 хүнд агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаар мэдээ мэдээллийг НЭМИС-тай хамтран танилцуулах, мөн өдөрлөг байгуулах өрхийн эмнэлэгийг сонгох, өдрөө товлдох,
- Өрхийн эмнэлэгүүдэд байршуулах постер болон брошурыг ДЭМНэдлийн хариуцсан ажилтнуудад өгч аль болох олон өрхийн эмнэлэгүүдэд тараалгах, танилцуулах материалаа булан хэлбэрээр бэлтгэх,
- Агаарын бохирдлын тархалт ихтэй 2 дүүргийн 1/1 өрхийн эмнэлэгийг сонгож өдөрлөгөө зохион байгуулах ба ингэснээр нөлөөллийн үнэлгээг гаргах боломжтой болно,
- Тухайн сонгосон өрхийн эмнэлэгийн ажилтнуудын илүү цагаар ажиллуулсан тохиолдолд цалин хөлсийг олгох.

УБЦАТ нь НЭМГ-ын санал болгосон арга хэмжээнүүдийг тусган талууд дараах байдлаар тохиролцоонд хүрлээ:

Хаана	Хэн	Зорилго	Хэзээ
Хангарьд ордон 14 давхарт	НЭМГ-ын харьяа 26 байгууллагын дарга удирдлагууд	Улаанбаатар хотын агаарын бохирдол болон хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаар илтгэл мэдээлэл - УБЦАТ	2014/ 11/ 17-21 хооронд, НЭМГ өдөр товлж мэдэгдэнэ
Хангарьд ордон 14 давхарт	Төвийн 6 дүүргийн ЭМН ийн 3/3 нийт 24 ажилтан	Улаанбаатар хотын агаарын бохирдол болон хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаар илтгэл мэдээлэл – УБЦАТ болон НЭМИСургууль	2014/11/24 – 28 хооронд өдрөө товлно
1/1 өрхийн эмнэлэг	Ярилцана	Ярилцана	2014/11/24 – 28

1. Арга хэмжээ 1: Хангарьд ордны 14 давхарт 26 байгууллагын дарга удирдлагуудад зориулсан / цай кофены завсарлага

ХАВСРАЛТ 3

АШУИС-ийн дэргэдэх НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ИХ СУРГУУЛЬ, ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГУУЛЬ

Уулзалтын зорилго:	Улаанбаатар хотын агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг иргэд олон нийтэд таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, харъяа байгууллагуудтай хамтран ажиллах.
Огноо:	2014 оны 11 дугаар сарын 12 өдөр
Хаана:	УБЦАТ, ТУН
Уулзалтанд оролцсон хүний нэр:	О.Мөнхтуултай - Орчны эрүүл мэндийн сургуулийн ажилтан Должин - УБЦАТ Ганчимэг - УБЦАТ Мөнхзул - УБЦАТ

Зорилго:

УБЦАТ нь нийслэлийн эмнэлэгийн байгууллагуудтай хамтран хотын агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг иргэд олон нийтэд таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлж улмаар нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилготой зохион байгуулж буй арга хэмжээнд НЭМИС-ийн Орчны эрүүл мэндийн сургуулийн баг хамт олонтой хамтран ажиллах.

Уулзалтын тухай:

УБЦАТ-ийн зүгээс ОЭМС-д зохион байгуулж буй арга хэмжээний талаар товч дурьдан дараах санал хүсэлтээ танилцууллаа:

3. Арга хэмжээ 1: АШУИС-ийн ОЭМ-ийн сургуулийн хүрээнд агаарын бохирдлын талаар хийж хэрэгжүүлсэн судалгаануудад үндэслэн, нийслэлийн 6 дүүргийн нэгдсэн эмнэлэгүүд болон өрхийн эмнэлэгүүдийн эмч ажилчдад зориулан өнөөдрийн Улаанбаатар хотын агаарын бохирдол хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буй талаар илтгэл танилцуулах,
4. Арга хэмжээ 2: Өрхийн эмнэлэгүүдэд зохион байгуулах өдөрлөгт хамрагдсан иргэд олон нийтээс авах санал асуулгын хуудсанд саналаа өгөх. Мөн тус арга хэмжээ нь агаарын бохирдлыг бууруулахад эрүүл мэндийн салбар иргэдтэй хамтран хийгдэж буй анхны тохиолдол тул ОЭМС нь өөрийн зүгээс санал зөвлөмжөө өгч, шаардлагатай судалгаагаа хийх боломжтой байгаа.

ОЭМС-ийн зүгээс бидний саналыг хүлээн авч ярилцаж дараах саналыг дэвшүүлээ:

3. Тус сургууль нь чиглэл чиглэлээ дагнан агаарын бохирдлын талаар судалгааг багш мэргэжилтэнгүүд хийдэг тул нэгдсэн байдлаар гаргасан агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн судлагаа байхгүй. УБЦАТ-с санал болгож буй илтгэлийг бэлтгэхийн тулд нийт хийгдсэн судалгааны дүгнэлт материалуудыг гүйцэтгэгч нараас нь авч нэгтгэх шаардлагатай.
Одоогийн байдлаар тус сургуульд хэд хэдэн агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаар хийсэн судалгаа байгаа ч заримых нь эцсийн дүгнэлт хараахан гараагүй байгаа.
4. Төслийн саналыг тэнхмийн эрхлэгчид танилцуулж, арга хэмжээнд оролцох багшийг томилуулж, бэлэн байгаа мэдээлэлдээ тулгуурлан илтгэлээ бэлтгэж оролцохоо илэрхийллээ.

Тус уулзалтын хүрээнд ярилцсаны үр дүнд дараах дүгнэлтэнд хүрлээ:

1. Эрүүл мэндийн салбар агаарын бохирдлын талаар судалгаа шинжилгээ хийж, төсөл хэрэгжүүлж байгаа ч бусад холбогдох салбаруудтай уялдаагүй байна,
2. Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл, хэрхэн сэргийлэх, иргэн өөрөө ахуйн хүрээндээ бохирдлыг яаж бууруулах талаар нийтэд хандсан мэдээ мэдээлэл үгүй байна.